



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 09 сарын 17-аар

Дугаар 8/409

Мандалговь

Г Ажлын хэсэг байгуулах тухай Т

Монгол Улсын Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.9 дэхь заалт, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд, Сангийн сайдын 2013 оны А-96/71 тоот тушаалын хавсралтаар баталсан "Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний ажлыг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх, таримал ойг үнэлэх, улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх журам"-ыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, аймгийн Засаг даргын 2018 онд байгуулсан гэрээнд тусгагдсан Ойжуулалт, ойн зурвас байгуулах, "Ногоон хэрэм" үндэсний хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн ойн зурвасын ажлын гүйцэтгэлийг шалган хүлээж авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулж ажиллуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч:

Н.Гантулга – Аймгийн БОАЖГазрын дарга

Гишүүд:

П.Очирбат – Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

Ц.Галбадрах – Сум дундын ойн ангийн дарга

Ж.Жамъяндагва - Сум дундын ойн ангийн мэргэжилтэн

Б.Цэрэнсүгир - БОАЖГазрын мэргэжилтэн

Хоёр. Ойжуулалт, ойн зурваст тарьж ургуулсан тарьц, суулгацын амьдралтын хувь хэмжээг бодитой тогтоож, акт, танилцуулгыг 2018 оны 9 дүгээр сарын 28-ны дотор холбогдох газруудад хүргүүлэхийг ажлын хэсэг (Н.Гантулга)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ

Ж.МӨНХЧУЛУУН



488010304